

## ДҮРС ОНОШИЛГОО

ЭХЭМҮТ Хүүхдийн эмнэлэгийн Радиологийн тасагт соронзон резонанст томографи (MRI), компьютер томографи (CT), рентген аппарат (DR), зөөврийн рентген аппарат ба мэс заслын рентген (C-arm), хэт авиан оношилгооны аппарат (Ultrasonography), ашиглан дараах шинжилгээнүүдийг хийж байна. Шинжилгээний дүрсийг дамжуулан, хадгалан шинжилгээний мэдээлэл болон дүгнэлтийг эмнэлгийн цахим сүлжээгээр дамжуулан эмчид тухайн агшинд нь хүргэдэг онцлогтой.



- I. Соронзон резонанс томографи (MRI): Тархи-харвалт ба уналт таталын, ураг, бүтэн нуруу нугас, элэг, цэс, нойр булчирхайн замыг шалгах, бага аарцгийн хөндийн, дээд, доод үе мөчдийн
- II. Компьютер томографи (CT): Дээд, доод мөчдийн болон цээж, хэвлийн гол судасны, толгой- гавал ясны, хэвлийн хөндий, цээжний хөндий, уушиг бага тунт , хамар-дайврын, чих, нуруу, нугалам ясны, үе, мөчдийн
- III. Рентген зураг: Цээжний, , гавал ясны, нурууны /хүзүү, сээр, бүсэлхий/, ууц, ахар сүүл, аарцаг ясны, эгэм, мөрний, хамар-дайвар хөндийн, аденойд ,хацар яс, ухархайн, чихний зургийг/ антрумын хөндий болон шюллер аргаар / өвдөг, мөр, түнхний үений, тавхай, гарын сарвуу ясны, дээд, доод мөчдийн яс , ирригография, урография, фистулографи, цистогграфия, гистросалфингография, эд эсийн хөгжлийн өөрчлөлттэй бүтцийн зураг ,шүдний дэлгэмэл зураг
- IV. Рентген харалт: Ходоод, нарийн гэдэс, бүдүүн, нарийн гэдэсний баритай шинжилгээ, пневмоирригографи ,цэсний замын болон бусад фистулографи, ялгаруулах урограмм, өгсөх уррграмм, цистограмм ,цээж, хэвлийн тойм харалт
- IV. Хэт авиан оношилгоо: Хэвлий, нярайн зулайгаар тархины хэт авиа , нүд, бамбай булчирхай , хөх, түнх болон бусад бүх үе, давсаг болон умайн дайвар пилорус болон гэдэс , төмсөгний хэт авиан шинжилгээ хийнэ